

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



VOL. 163

Yүсгэн байгуулагчийн сургаал

Хүний сул дорой талыг мэддэг хүн байх нь

Есүс Христэд 12 дагалдагч гэж нэрлэгддэг туйлын шалгарсан авъяастай шавь нар байжээ. Тэдгээр шавь нар нь Есүсийг баривчлагдан явахад “энэ хүнийг танихгүй” гэж хэлж багшаасаа урвадаг. Гэвч загалмайд цовлогдон амиа алдсан Есүс нь дахин амилаж, шавь нартайгаа уулзахдаа, өөрөөс нь урвасан гэдгийг мэдсээр байж шавь нарыгаа огт буруутган зэмлэдэггүй. Үүнийг харсан шавь нар нь буруугаа хүлээн гэмшиж, ондоо хүмүүс болцгоодог. Тэгээд амь насаараа дэнчин тавин сургаалыг түгээснээр Есүсийн сургаал, номлол орчин цагт дамжин ирсэн.

Есүс нь хүний сул дорой байдлыг мэдэхийн дээдээр мэддэг, түүнийг нь уучилж, хүлээн авах уужим сэтгэлтэй нэгэн байсан. Өөрийнх нь сул тал, алдаа дутагдлыг бүгдийг нь уучлан хүлээн авах хүнтэй учрах үед хүмүүс “энэ хүнд өөрийнхөө бүх

зүйлийг даатгахад ямар ч харамсах зүйл алга” гэж бодоод, амьдрах арга барилаа 180 хэм өөрчлөх тохиолдол байдаг.

Бурханы шавь болсон бидний хувьд бүгдийг хүлээн авч, алгаа дэлгэн тэврэх хүн бол Бурхан багш юм. Бурхан багшийн нигүүлсэнгүй сэтгэлийг хамаг амьтдад мэдрүүлэх зорилгоор гарч ирдэг түүний хувилгаан дүр бол Жанрайсаг. Жанрайсаг нь 33 дүрд хувилж, авралыг хүсэмжлэх хүн дээр очиж авралын гараа сунгадаг байна. Тэрхүү нигүүлсэнгүй сэтгэлийг нь мэдэрсэн хүмүүс, Жанрайсаг бурхан шиг болохыг хүсэн нэгэн сэтгэлээр зүтгэхэд, нэг насаараа сургаал түгээх үйлсэд зүтгэх хүн ар араасаа төрөн гарч ирдэг.

Yүсгэн байгуулагчийн сургаал 9, X.146-147

Living the Lotus Vol. 163 (2019,04)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б.Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Yүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Анхилуун үнэртэй салхи лугаа



Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Сэтгэлд сэвэлзэх анхилуун үнэртэй салхи

Рёокэн Тароогийн бүтээл болох “цэцэг” нь Японы хаврын үзэмжийг туйлын уран яруу илэрхийлсэн дууны нэг яах аргагүй мөн. Хүн болгоны сайн мэддэг дуу. Хавар ирснийг илэрхийлэх гол зүйл бол сакура цэцэг билээ. Гэвч сакура цэцэгнээс урьтаж, чавга хийгээд яргуй, буйлс модны цэцгийн анхилуун үнэрийг өөртөө шингээсэн салхи сэвэлзэхэд хавар айлчлан ирснийг мэдэрдэг хүн цөөнгүй болов уу. Энэхүү хавар ирсэн баяр хөөрийг илэрхийлэхтэй төстэй үг Цагаан Лянхуан судрын “Удиртгал” бүлэгт гардаг.

“Зандангийн үнэрт салхин Амьтны сэтгэлийн баясгамуй” (орч.Болдбаатар.Т УБ.,(2012), “Адмон принт” хэвлэл, 38 тал) гэсэн үгийг Үүсгэн байгуулагч “бурханы анхилуун үнэртэй салхи нь хамаг амьтны сэтгэлд түрэн орж ирэхэд баяр хөөр үүснэ” хэмээн тун ойлгомжтой тайлбарласан байна.

Бурханы сургаалтай учирсан бид гайхамшигт сургаалыг сонсож, суралцаж, хэрэгжүүлэх явцад олон зүйлийг анзаарч сурдаг. Тааламжгүй байсан хүндээ талархдаг болж, мөн өөрт зугаатай санагддаг байсан зүйл нь аминч үзлийг тэтгэхээс хэтрэхгүй зүйл байсан гэдгийг анзаарч ойлгоход, амьдралыг үзэх үзэл өөрчлөгддөг.

Ийнхүү жинхэнэ чухал зүйл юу болохыг анзаарах үед бидний сэтгэл зовлон шаналалаас ангижирч, баяр хөөр, амар амгаланг мэдэрдэг. Үүнийг бид сургаалын ачаар аврагдлаа хэмээн хэлдэг. Энэ л Үүсгэн байгуулагчийн хэлээд байгаа “баяр хөөр үүснэ” гэсэн нөхцөл байдал бөгөөд тэр үед тухайн хүн “баяр хөөрийг мэдэрч байгаа” юм. Дашрамд хэлэхэд дээр дурьдагдаж буй “баяр хөөр” хэмээх үг нь сэтгэлд тээглээд байсан зүйлийг авч хаяхад мэдрэгдэх хөнгөрөх мэдрэмжийг хэлж байгаа юм.

Бид бүхэн Бурхан багштай учрах боломжгүй. Гэвч Их ариун ордонд очихдоо сургаал номлолоос Бурханы нигүүлсэхүйг олж хараад, тухайн сургаалыг хэрэгжүүлснээр амьдралын баяр баяслыг мэдэрсэн хүмүүсийн илтгэлийг сонсоход бидэнд ч гэсэн сайхан санагддаг. Энэ нь “Зандангийн үнэрт салхин Амьтны сэтгэлийн баясгамуй” гэсэн судрын мөр шиг сургаалын гайхамшигт хүч цээжинд түрэн орж ирдэг болохоор юм. Шагжамүни бурхан багшийн амьдарч байсан цаг үед ч, одоо цаг үед ч энэ өөрчлөгдөхгүй зүйл юм.





Бүх хүн “буянтай хүн”

Эчигогийн Рёокан ламтан ч гэсэн дээр дурьдсан “Зандангийн үнэрт салхин Амьтны сэтгэлийн баясгамуй” гэдгээс санаа авсан уу “насан туршдаа анхилуун үнэрээр бусдыг тэтгэнэ” гэдэг үгийг амьдралын зарчмаа болгосон байдаг. “Насан туршдаа бусдад зөөлөн эелдэг хандаж, хүмүүст хайр энэрэлийг түгээж, баяр хөөрийг бэлэглэх анхилуун үнэрт салхи лугаа хүн байх болно” хэмээн дотроо шийдээд, тэр дагуу амьдарсан гэдэг.

Дармапада сударт “буянтай хүний үнэр салхины эсрэг зүг байсан ч тархан түгнэ”, “буянтай хүний үнэр бүх зүгт үнэртэнэ” гэж гардаг. Эндээс бусдад “баяр хөөр”-ийг түгээхэд “буянтай” байх хэрэгтэй гэж дүгнэж болохоор байна. Мөн би буян муутай хүн, тэр хүн их буянтай гэх зэрэг үгс их сонсогддог ба бурханы үйл, сайн үйлийг их хийвэл “буян” их хурдаг байж болох л юм.

Гэвч миний хувьд дээрх үгтэй санал нэгдэхгүй байна. Бид одоо энэ ертөнцөд амь насыг хүртээд амьдарч байгаа маань их байгаль дэлхийн хишиг гарцаагүй мөн бөгөөд өвөг дээдэс, эцэг эхийнхээ буяныг хүртсэн учраас юм. Тиймээс бид хаа нэгтгээгээс буяныг хайх биш өөрийнхөө “буян”-ыг олж анзаарахад л хангалттай. Буянаа олж анзаараад, түүнийгээ хөгжүүлж чадвал хэн ч байсан хаа сайгүй тархан үнэртэх анхилуун үнэрт салхи лугаа “буянтай хүн” болох болно.

Ийм хүн болоход “баярламаар, талархмаар” гэсэн сэтгэлтэй байх их чухал. Ямар ч тохиолдолд талархалыг мартдаггүй, даруу төлөв хүнд хүмүүс өөрийн мэдэлгүй татагддаг. Ийм зан төлөвтэй байхын дээр өөдрөг, эелдэг, дулаанаар бусдад хандаж, тийм үгийг хэлдэг бол таны буяныг илүү үнэ цэнэтэй болгох нь гарцаагүй. Бусдын сайн сайхны төлөө бодсон хандлагатай байхад сургаалын анхилуун үнэртэй салхи сэвэлзэх лугаа тархаж, бусдад тайтгаралыг бэлэглэнэ.

Шагжамүни Бурхан багшийн мэндэлсэн өдөр тохиох 4-р сард Хэйсэйгийн он тоолол (Японд шинэ хааныг сэнтийд залрахад он тооллыг шинээр тоолж эхэлдэг уламжлалтай. Одоогийн хаан болох Акихитогийн он тооллыг Хэйсэй буюу энх тайванд хүрэх, цогцлоох гэж нэрлэдэг байна) солигдох болно. Энэ нь энх тайвны төлөөх үйл ажиллагааг хайрцаглагдсан нэгэн хэвийн болгохоос сэргийлж, сэтгэлээ дахин нэг шинээр өөрчлөх завшаан гэж би хүлээн авч байгаа. Бурхан багшийн сургаал хэмээх анхилуун үнэртэй салхийг түгээх замнал нь урьд урьдынхаасаа ч чухал болох болно.

«Косей» сэтгүүлийн 2019 оны 4 сарын дугаараас



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар

Хувилгаан балгасаар зүйрлэхүйг үгүүлэх 7-р бүлэг



“Сүслэн «Үлгэр зүйрлэл», «Сүслэн авахуй», «Эмийн өвс» бүлгүүдэд гол төлөв Бурхан ба бурханы сургаал түүний үйлчлэл ямар байдгийг үлгэрлэн тайлбарласан. Гэвч ингээд ч сургаалыг ойлгоогүй хүмүүсийн төлөө энэ «Хувилгаан балгасаар зүйрлэхүй бүлэг»-ээс «Суралцагч, үл суралцагч нарт эш үзүүлснийг үгүүлэх 9-р бүлэг»-ийг айлддаг. Эдгээр бүлгүүдэд Бурхан ба хүмүүсийн өмнөх наснаас өнөөг хүртэлх хувь тохиоллын талаар голчлон айлддаг.

«Хувилгаан балгас бүлэг»-т бурханы шавь нарын энэ насны бурханы үйлийг сайшааж, ирээдүйд бурханы гэгээрэлд хүрч чадна гэсэн итгэлийг өгөхийн тулд хүмүүс өмнөх наснаасаа Бурхантай гүн гүнзгий сэжмээр холбогдсон байдгийг айлдаг. Үүгээрээ бурханы сургаал мөнхийн, хувиршгүй бөгөөд хамаг амьтан бурханлаг чанартай, тиймээс тэд хэзээ нэгэн цагт бурханы түвшинд хүрч чадна гэдгийг сургасан байна.

амьдардаг эгэл жирийн хүн байсан мөртлөө хамаг амьтны тусын тулд хязгааргүй олон жил бурханы үйлд шамдсанаар сая Будда болсон байна. Үүнээс үзэхэд бид ч гэсэн бурханы гэгээрэлд хүрэх боломжтой юм байна. Ийм сайхан зүйл гэж хаа байх вэ. Та бидэнд сургаалаа айлдан соёрхоно уу” хэмээн хүсэв. Дараа нь 16 ханхүү ч гэсэн сургаал айлдахыг хичээнгүйлэн хүсэж гэнэ.

Тэгтэл Их Билиг лүгээ Нэвтэрсэн Ялгуусан Бурхан тэнд цугласан олон түмэнд хандан “Энэ 16 залуу хувраг бодисадва нар бол урд наснаасаа олон бурхадых тахиж, дэргэд нь бурханы үйл хийж, үргэлж хамаг амьтанд Оройн Дээд Цагаан Лянхуа Судар хэмээх сургаалыг айдлан хязгааргүй олон хүмүүсийг бурханы зам мөрд оруулсан билээ. Тэдгээр хүмүүс нэг төрөлдөө ч биш, дахин төрөх болгондоо өөрийг нь зам мөрд оруулсан бодисадватай учирч, мөн адил сургаалыг нь сонссоноор сургаалд сүсэглэж, ойлгодог болсон юм” хэмээн айлдав.

Их Билиг лүгээ Нэвтэрсэн Ялгуусан Түүнчлэн ирсэний уг явдал

“Каашяпа, Сургаал маш эрт цагт, хүний ухаанаар бодохын аргагүй маш эрт дээр үед Их Билиг лүгээ Нэвтэрсэн Ялгуусан Түүнчлэн ирсэн хэмээх бурхан байжээ хэмээн эхэлдэг. Тэр бурхан сахил хүртэхээсээ өмнө нэгэн улсын ханхүү байсан ба 16 хүүхэдтэй, том хүүг нь Билиг Хурсан гэдэг байв. Билиг Хурсан ба дүү нар нь бага залуугаараа сахил хүртсэн аав нь алс холын нутагт олон жил бурханы үйл хийснээр бурханы гэгээрэлд хүрснийг сонсоод аавынхаа дэргэд бурханы үйл хийхээр шийдэн аян замд гарчээ. Эх, садан төрлийн эгч нар нь нулимс урсган үдэж өгөв. Түүнчлэн өвөө нь болох Их Билиг лүгээ Нэвтэрсэн Ялгуусан Түүнчлэн ирсэний эцэг ч гэсэн олон түмэн сайд түшмэд, ард иргэдээ дагуулан хамт явсан байна. Эцэг хаан “Бурхан багш та угтаа бидэнтэй хамт





Замбуутивын Шагжамүни Түүнчлэн ирсэн Бурхан

Шагжамүни будда ийнхүү эрт дээр цагийн явдлыг ярьсны дараагаар хоолой засан “Одоо маш чухал зүйл ярих тул та нар сайтар сонсогтун. Тэр 16 бодисадва нар дараа нь будда болсон ба одоо ч гэсэн 10 зүгийн улсад сургаалаа айлдаж байгаа” хэмээн өгүүлээд тэдгээр бурхадын болон сургаал түгээж буй улсын нэрийг дурдана. Үргэлжлүүлэн тэдгээрийн 16 дахь нь Шагжамүни будда би ба замбуутивд гэгээрлийг олж, замбуутивын улс оронд сургаал түгээх үүрэгтэй, мөн өмнөх насандаа Оройн Дээд Цагаан Лянхуан сургаалыг айлдан бурханы зам мөрд оруулсан хамаг амьтан бол одоогийн шавь нар, ирээдүйн сүсэгтэн (өнөөгийн хүмүүс бид нар) юм гэдгийг хэлж өгнө.

“Та бүхэн сонсогтун. Бурхан (хүн болж төрсөн бурхан) үргэлж энэ ертөнцөд байгаад байдаггүй. Сургаалаа айлдаад дуусчих юм бол хэсэг хугацаанд ертөнцөөс холдон оддог. Олон түмэн бурханы сургаалд чанд хатуу итгэн сүсэглэж, ойлгож, хүн бүрт эрх тэгш үйлчилдэг жинхэнэ үнэний хуулийг сайтар ойлгож, сэтгэл тогтуун шийдмэг болсон цагт энэхүү Оройн Дээд Цагаан Лянхуа сургаалыг айлддаг. Эрт дээр үед тийм байсанчилан одоо ч гэсэн ийнхүү айлдсаар л байгаа юм.”

“Ертөнцөд жинхэнэ гэгээрэлд хүргэх хоёр янзын сургаал байдаг юм биш. Цорын ганц Оройн Дээд Цагаан Лянхуа сургаал л бий. Гэвч Түүнчлэн ирсэн хамаг амьтны зан чанар, ойлгох чадварыг ухааран мэдэж түүнд нь таарсан уран арга (бодит арга барил) хэрэглэдэг. Таван мэдрэхүйн хүсэл шуналдаа хүлэгдэн өөрөө өөртөө зовлон хураадаг хүн ч байдаг тул тийм хүмүүсийг эхлээд төөрөгдлөөс нь ангижируулж, сэтгэлийн амар амгаланд хүргэх замаар заан чиглүүлдэг. Үүнийг үлгэр жишээ татан тайлбарлая.”

Ийнхүү Цагаан лянхуа судрын долоон үлгэрийн дөрөв дүгээрх болох “Хувилгаан балгас дахь эрдэнийн үлгэр”-ийг айлддаг. Үлгэр дараах агуулгатай.

Хувилгаан балгас дахь эрдэнийн үлгэр

Нэгэн газар зорьсон газартаа хүрэхэд бэрхшээлтэй их урт, бартаатай зам байв. Тэр газар хүний хөлийн газраас хол алслагдсан, араатан амьтантай туйлын аймшигтай газар байжээ. Гэтэл ховор нандин эрдэний эрэлд гарсан хэсэг хүмүүс тэр бартаат замаар явж байв. Тэдэн дотор нэгэн ахлагч байх ба билиг оюун хурц, аливаад өөдрөг хүн бөгөөд тэр зам ямар зам болохыг, замын төгсгөлд юу байгааг сайтар мэднэ.

Хүмүүс дотор хөл муутай, тавьтаргүй гэх мэт янз бүрийн хүн байх тул замдаа ядарцаагаад ахлагчдаа хандан “Бид ядарч сульдаж гүйцлээ. Энэ зам ч гэсэн нэг л аймшигтай болохоор үүнээс цааш явах хүсэл алга. Цаашаа урт зам байгааг ч хэлэх үү, бид эртхэн буцмаар байна.” гэцгээв.

Ахлагч цаг хугацаа, нөхцөл байдалд тааруулан хүмүүсийг удирдан чиглүүлэх арга (Уран арга)-ыг сайн мэддэг тул дотроо “Ямар





өрөвдмөөр юм бэ. Юунд дахиад жоохон яваад хүрэх агуу том эрдэнээс татгалзан буцна гэнэ вэ. Жаахан л тэвччихэд болох байхад” хэмээн бодоод уран аргын хүчээр тэр бартаат замын талаас цаахантай нэгэн сүрлэг балгас босгож гэнэ. Тэгээд хүмүүст хандан “Та бүхэн одоо айж сандрах хэрэггүй. Мөн буцаж явах ч шаардлагагүй. Тэр балгас дотор амарцгаа. Тийшээ орвол сэтгэл тайвширах болно” гэв.

Хүмүүс ихэд баярлан тийшээ очиж амарцгаав. Хэсэг хугацааны дараа ахлагч хүмүүсийн ядаргаа тайлагдсаныг хараад балгасыг алга болгоод “За явцгаая. Эрдэнэ байгаа газар энүүхэнд байна. Сая энд байсан балгасыг үнэндээ би хуурамчаар босгосон юм. Энэ бол та бүхнийг амрааж, сэтгэлийг засах уран арга байсан билээ.”

Ийнхүү хүмүүсийг зоригжуулаад эрдэнэ байгаа газар руу үргэлжлүүлэн явсан ажээ. Гэхдээ ийнхүү батлахад заавал нөхцөл дагалдаж байдаг. Тэр нь “ийм ийм бурханы үйл хийсний дараа ...” гэсэн нөхцөл байдаг. Өөрөөр хэлбэл бурханы гэгээрлийг олох их сургуульд тэнцлээ гэсэн үг болохоос биш төгсөлтийн диплом биш. Үргэлжлүүлээд заавал суралцах шаардлагатай гэсэн үг юм. “Үлгэрлэл бүлэг”-т тойруулан хэлсэн “бусдын хүч” ба “өөрийн хүч” гэдэг зүйл энэ бүлэгт дахин өөр хэлбэрээр гарч ирж байгааг анхаарууштай.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”; Косей хэвлэлийн компани, 2016, X. 73-74



Анхилуун үнэрийг түгээх замнал

Сакура цэцэг дэлгэрэх хаврын улиралыг угтаад байна. 4-р сар бол Бурханы шашинт хүмүүсийн хувьд Шагжамүнигийн төрсөн өдөр тохиох тэмдэглэлт сар юм. Цэцгийн үнэр хүмүүст хаврын баяр баяслыг бэлэглэдэг шиг хүн бүр анхилуун үнэрт салхи лугаа хүн болж, бусдын сэтгэлийг тайтгаруулах учрал болох нь ямар чухал зүйл вэ гэдгийг Нивано ерөнхийлөгч энэ сарын сургаалаараа бидэнд заажээ.


Тийм “буянтай хүн” болохын тулд талархалыг мартдаггүй, төлөв түвшин, даруу зантай байх чухал гэжээ.

Бурханы сургаал гэсэн анхилуун үнэрийг түгээх замнал нь бурханы шавь бид нарын үүрэг бөгөөд өөдрөг, эелдэг, дулаан үг үйлдэлээр бусадтай холбогдох- ийм л хүн болохын төлөө хичээцгээе.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Сайтоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224
 e-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
 e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
 e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
 P.O. Box 692148, San Antonio, TX 78269, U.S.A.
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
 e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
 Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
 e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740 U.S.A.
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
 e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona
Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
 e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
 Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
 e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
 Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
<http://rkchi.org/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303
 e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
 Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
 CEP 04116-060 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377 Fax: 55-11-5549-4304
 e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
 CEP 08730-000 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100, Taiwan

Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701, Taiwan

Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,
Republic of Korea

Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan

Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224

e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibrk-rk.org/>

Branches under the Headquarters**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia

Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation

Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of South Asia Division**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division**Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu,
Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna**Rissho Kosei-kai of Singapore****Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh

Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh

Tel & Fax: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station:
Mirshari, District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar,
Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu**Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka

Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Branches under the Headquarters****Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia

Tel & Fax: 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris**